



Хил хамгаалалтын онол, түүх

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ОНОЛ, УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨШҮҮРЭГ ЦАГИЙН БАЙДАЛ ДОТОР БИЙ

Хилийн цагийн байдлын шинж байдал, хэлбэр агуулга өөрчлөгдөхийн хэрээр хил хамгаалалтын тактик ажиллагаа өөрчлөгдөн сайжирч боловсронгуй болж байдаг нь хил хамгаалалтын онол, урлаг хөгжих зүй тогтол юм.

Зэргэлдээ орноос шууд дайсагнасан ажиллагаа явуулж байсан, эсвэл тийм нөхцөл бий болсон үед дан ганц цэргийн хүчээр хил хамгаалалтыг зохион байгуулдаг байжээ. "Хүйтэн дайн"-ы жилүүдэд энэ маягийн хамгаалалт хийгдэж байв. Энэ нь өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Гэтэл олон улсын харилцааны төлөв байдал эрс өөрчлөгдөн дэлхийн улс гүрнүүд илүү нээлттэй болж цэрэг, улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд хамтын ажиллагаа өргөжихийн хэрээр улсын хилээр гардаг зөрчлийн хэлбэр, агуулга өөрчлөгдөн, зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, улмаар хил орчмын оршин суугчид, хил хяналтын байгууллагуудын ажилтнууд хилийн хамгаалалтад оролцож тусалж дэмжих болжээ.

Газар орон, хил хамгаалалтын байдлыг сайн мэдэх, хил орчмын оршин суугчид, хилчид, хил хяналтын байгууллагын ажилтнууд хил зөрчигч нартай илэрхий хуйвалдан, өөрсдөө зөрчил гаргадаг болсон нь хил хамгаалалтыг зөвхөн хилчдээс бүрдсэн дан ганц хилийн манаагаар хамгаалах боломжгүй болсныг харуулж байна.

Хилийн зөрчил хэн, хаагуур, хэзээ гарч болохыг урьдчилан тааварлах буюу мэдэх боломжгүй, хүч хэрэгслийн хүрэлцээ муу, мэдээлэл авах эх сурвалжгүй зэргээс улсын хилийг хамгийн тэргүүний хилчдээр хамгаалуулсан ч хилийн зөрчил гаргуулахгүй байх баталгаа алдагдаад байна. Энэ нь улсын хилийг зөвхөн цэргийн хүчээр найдвартай хамгаалах боломжгүй гэдгийг харуулж байгаа хэрэг юм.

Өөрөөр хэлбэл хил хамгаалалтад гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл, орон нутгийн иргэд, тухайн чиглэлд ихэвчлэн гардаг хэрэг зөрчилтэй тэмцэх үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хүчийг ашиглах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа бөгөөд

улсын хилийн хамгаалалтын бүтцэд үүрэг зорилго, арга ажиллагаагаараа харилцан адилгүй хэд хэдэн биеэ даасан элементүүд орж ирэх нь гарцаагүй болж байна.

Үүнээс үүдээд хил хамгаалалтын байгууламж гэсэн шинэ ойлголт гарч ирэх нь зайлшгүй боллоо.

Тухайн хэсгийн хил хамгаалалтад оролцож байгаа дээр дурдсан хүч хэрэгслийн бүлэглэл нь хил хамгаалалтын байгууламжийн элементүүд байх болно.

Байгууламж гэдэг нь аливаа юмс үзэгдлийн харилцан холбоо бүхий гол бүрэлдэхүүн хэсгийг хамтатган нэрлэсэн нэр юм.

Тийм болохоор ерөнхий цэргийн байлдаанд хориглолтын байгууламжийг авч үзэхдээ:

- Цэргийн бүлэглэл, түүний оперативын байгууламж /байлдааны журам/
- Хориглолтын зааг, район, байруудын систем
- Галын систем
- Танк эсэргүүцэх, агаараас эсэргүүцэн хамгаалах, десант эсэргүүцэх системүүд
- Инженерийн саадын систем зэргээс бүрдэнэ гэж үздэг

Иймд хил хамгаалалтын байгууламжид юуг ойлгож болох, түүнд юу багтаж болох талаар саналаа дэвшүүлэхэд дөхөмтэй байна.

Байгууламж гэдэг үгийн утга, түүнийг цэргийн шинжлэх ухаанд хэрэглэдэг байдлаас үзвэл **улсын хил хамгаалалтыг нэгдсэн бодлого төлөвлөгөөтэйгөөр явуулахад зайлшгүй шаардлагатай хүч хэрэгслийн бүлэглэл, үйл ажиллагааны системүүдийн цогцыг хил хамгаалалтын байгууламж гэж** нэрлэж болох юм. Үүнийг Монгол-Оросын хилийн тодорхой хэсэг дээр авч үзвэл бодит байдал дээр:

- Хилийн манаа, харуулууд /хил хамгаалалтын заагууд дахь/
- Тухайн хэсгийн хамгаалалтад тодорхой үүрэгтэйгээр оролцож байгаа орон нутгийн иргэд
- Гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл
- Хил орчмын иргэдийн дунд зохиох ажил
- Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагын үйл ажиллагаа
- Бусад харилцан ажиллагаатай байгууллагуудын бие даасан бүлэглэлүүд
- Инженерийн саадын систем /Инженер техникийн систем/ зэрэг элементүүдээс бүрдэж байна гэж үзэж болно. Энэ нь одоогоор Монгол-Оросын хилийн зөрчлийг таслан зогсооход ашиглаж болох хил хамгаалалтын байгууламжийн хувилбар юм.

Дээрх чиглэлд гарч байгаа хилийн зөрчилд дүн шинжилгээ хийж үзэхэд гол төлөв мал хулгайлах, алдсан малаа хайх хэлбэрээр гардаг байна. Гэхдээ энэ нь:

1. Зэргэлдээ улсын нутагт нэвтрэн орж, мал хулгайлах
2. Өөрийн улсын нутаг дэвсгэрээс мал хулгайлж зэргэлдээ улсад амьдардаг хамсаатнууддаа дамжуулах
3. Алдсан малынхаа орыг олж авахаар "шархаа нөхөхөөр" /улсын хилийг зөрчих /Ийм зорилго тавьсан хил зөрчигчид хамгийн аюултай байдаг. Учир нь ямар ч үнээр, ямар ч аргаар болов орыг нь олж авч "шархаа нөхөх" зорилготой байдаг тул зэвсэг хэрэглэж бусдын амь насыг хохироох буюу хилийн зөрчил, будлиан үүсэхэд хүрч болзошгүй юм/
4. Алдсан малаа олж авахаар хил зөрчих зэрэг зорилготой байдаг байна.

Үүнээс үүдээд дээрх хэлбэрийн хилийн зөрчилтэй тэмцэх арга өөрийн гэсэн онцлогтой байх шаардлага амьдралаас урган гарч байна.

Гарч байгаа хилийн зөрчил аль ч талын хил орчмын газар орон, хил хамгаалалтын байдлыг сайн мэдэх, хил орчмын оршин суугчдаар гол төлөв үйлдэгддэг тул цөөн хүний хүчээр энэ их өргөн уудам нутгийг хий зайгүй хамгаалах боломжгүй байдалд хүргэдэг. Энэ нь хил орчмын ард иргэдийн дунд идэвхитэй ажиллаж, хилийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байхыг шаардаж байна. Чухамдаа үүнийг гүйцэтгэх ажлын хүч хэрэгслээр шийдэж чадна.

Харин алдсан малаа олж авахаар, эсвэл орыг нь ч боловч олж авч "шархаа нөхөх"-өөр хил зөрчдөг хүмүүсийн хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх, хилийн халдашгүй дархан байдлыг ойлгуулж, үүрэг хариуцлагыг нь ухамсарлуулах асуудлыг шийдэх арга замыг зааж өгөх, улмаар асуудлыг нь хүндрэл чирэгдэлгүй шийдвэрлэж өгөх зэрэг олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр ийм зорилгоор хил зөрчдөг хүмүүсийн тоог эрс бууруулж улмаар энэ төрлийн зөрчлийг таслан зогсоох боломж бүрдэх юм.

Мөн хилийн зөрчил ихээхэн гардаг буюу тийм боломж бүхий газар орныг инженер техникийн хэрэгслээр хангах замаар хилийн зөрчлийг илрүүлэх, хил зөрчигчдийн чөлөөтэй нэвтрэх хөдөлгөөнд саад учруулах боломжийг нэмэгдүүлснээр хил хамгаалалтын үр дүн дээшилнэ.

Монголд мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэг байгуулагдан үйл ажиллагаагаа явуулаад нэлээд олон жилийн нүүр үзэж багагүй амжилтад хүрч байна. Энэ мэт төрийн болон хувийн өмч хөрөнгө, иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа

явуулж буй төрийн болон төрийн бус олон байгууллага ажиллаж байна. Тэдэнтэй гар, санаа нийлж хүчээ нэгтгэн ажиллаваас ядаж л бие биенийхээ малыг хулгайлж хил давуулдаг, өс хонзон санаж бусармаг ажиллагаа явуулдгаа болихсон билээ.

Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хилчдээс гадна сахилга хариуцлагатай, нийгмийн идэвхи сайтай хил орчмын оршин суугчид бусад хүмүүсийг өөрсдийн нь сайн дурын үндсэн дээр татан оролцуулж, зохих урамшил, хөлс олгож ажиллуулбал амжилтад хүрэх боломж байгаагийн дээр ийм туршлага ч цөөнгүй байдаг.

Энэ бүгдийг нэгтгэж дүгнэж үзвэл хил хамгаалалтын байгууламжид дээр дурдсан элементүүдийг хамруулж үзэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Ийм учраас Хилийн Цэргийн штаб дээрх санааг дэвшүүлэн тавьж, хил хамгаалалтын шинэ хувилбаруудыг боловсруулж ашиглахаар тусгай бүлэг томилон ажиллуулж байна. Онолын дээрх дүгнэлийг бататгах зорилгоор ойрын үед хилийн зарим хороо, сумангийн хэсэгт хил хамгаалалтын шинэ хувилбарыг туршиж эхлэх бөгөөд хил хамгаалалтын онол урлагийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, авьяаслаг хилчдийнхээ санал бодлыг сонсохоор энэхүү өгүүллийг толилуулж байна.



ЦШУ-ны доктор /Ph.D/,
дэд профессор П.Даш